

Аудит хийгдсэн байгууллага:  
Дархан сумын Засаг даргын  
тамгын газар

Огноо: 2025.06.13



ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Байгууллагын дотоод аудит  
Жил: 2023, 2024 он

Огноо 2025 он

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН  
ГАЗАР

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:

ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АУДИТЫН ТӨРӨЛ: БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА : 2025.05.19-2025.06.13

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА: Л.ДАГИЙСҮРЭН

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮД:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ: М.ГАНЦЭЦЭГ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ: Ш.ОТГОН

## АГУУЛГА

|                                        |    |
|----------------------------------------|----|
| 1. ТАНИЛЦУУЛГА                         | 4  |
| 1.1. Засаглалын хүрээнд                | 4  |
| 1.2. Эрсдэлийн удирдлагын хүрээнд:     | 5  |
| 1.3. Дотоод хяналтын хүрээнд           | 5  |
| 2.1. Аудитын зорилго:                  | 5  |
| 2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт | 6  |
| 2.3. Аудитын арга, аргачлал            | 6  |
| 3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА          | 7  |
| 3.1. Засаглалын талаар                 | 7  |
| 3.2. Эрсдэлийн удирдлагын талаар       | 7  |
| 3.3. Дотоод хяналтын системийн талаар  | 8  |
| 4. АУДИТЫН ҮР ДҮН                      | 8  |
| 4.1. Засаглалын хүрээнд                | 8  |
| 4.2. Эрсдэлийн удирдлагын хүрээнд      | 9  |
| 4.3. Дотоод хяналтын хүрээнд:          | 10 |
| 5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ                     | 13 |

## 1. ТАНИЛЦУУЛГА

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-25-02/17 дугаар удирдамжийн дагуу Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

### 1.1. Засаглалын хүрээнд

Дархан-Уул аймгийн Дархан сум нь 1961 оны 10 дугаар сарын 17-нд анх байгуулагдсан ба 2024 оны эцсээр Дархан сум нь 30700 гаруй өрхийн 90000 гаруй хүн амтай байна.

Сумын Засаг даргын тамгын газар нь төрийн захиргааны 53, төрийн үйлчилгээний 35, улс төрийн албан тушаалтан 20, гэрээт 6 ажилтан нийт 114 ажилтан албан хаагчтай ард иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна. Тамгын газрын дарга нь үйл ажиллагаагаа Засаг даргадаа тайлагнадаг байна.

Засаг дарга түүний Тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах, Засгийн газар, хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх, Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага иргэдээс ирүүлсэн өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах үндсэн үйл ажиллагаатай.

Даргын зөвлөлөөр үйл ажиллагааны ажлын тасралтгүй байдал, албан хаагчдын ажиллах нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөцийн хомсдол үүсэх хор хохирол, тулгамдаж буй асуудал, гэнэт үүссэн эрсдэл, ирээдүйд бий болох үр дагаварыг үнэлж төсөвтэйгээ уялдуулан, санхүүгийн хууль дүрэм, журамтай нийцүүлэн эрэмбэлж шийдвэрлэдэг. Сонгуулийн үр дүнгээр томилогдсон Засаг дарга мөрийн хөтөлбөрт тусгасан заалтаа хэрэгжүүлэхийн тулд Засаг даргын үйл

ажиллагааны хөтөлбөр боловсруулан батлуулж, түүний дагуу стратеги зорилтоо тодорхойлдог байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, эрхэмлэх зүйлийн талаарх албан хаагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарч үүрэг чиглэл өгч, байгууллагын дотоод журамд заасны дагуу дэмжих шагнаж урамшуулдаг байна.

Хөндлөнгийн болон дотоод аудитын дүгнэлтийг үндэслэн тулгамдаж буй эрсдэлт асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлыг заавар, зөвлөгөө, байгууллагад учирч байгаа төсөв санхүүтэй холбоотой асуудлыг сумын Засаг даргад танилцуулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг байна.

### **1.2 Эрсдэлийн удирдлагын хүрээнд:**

2024 оноос эхлэн Дархан сумын Засаг даргын тамгын газар нь ISO 9001:2016 стандартыг хэрэгжүүлэх зорилгоор Эрсдэлийн удирдлагын журам, Үл тохирлын хяналтын журам, Залруулах сэргийлэх арга хэмжээ зэрэг 34 журмыг боловсруулсан байна. Эрсдэлийн удирдлагын тусдаа газар, нэгж үгүй.Тулгарч байгаа эрсдлийн талаар тухай бүр Засаг даргад танилцуулж тайлан мэдээлдэг. Аливаа эрсдэлийн талаар албан хаагчдад хурлын шийдвэрийг танилцуулдаг.

### **1.3 Дотоод хяналтын хүрээнд**

Дархан сумын Засаг даргын тамгын газар нь дотоод хяналтын бодлого журамтай боловч, тусдаа нэгж байхгүй, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хязгаарлагдмал хүрээнд хийж байна. Тухайлбал:

- Авлига эсрэг төлөвлөгөө, Ёс зүйн хорооны тайлангаар хяналт тавьж байна
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг дотоод ERP системд хянадаг
- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг дотоод ERP системээр хянадаг
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үнэлж урамшуулдаг.

## **2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ**

### **2.1 Аудитын зорилго:**

Дархан сумын Засаг даргын Тамгын газрын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж, дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө зөвлөмж өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

**2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт**

Дотоод аудитад Дархан сумын Засаг даргын Тамгын газрын 2023-2024 оны засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явц, санхүүгийн үйл ажиллагаа, цалин хөлс олголт, анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, худалдан авах ажиллагаа, өмнөх шалгалт, шилэн дансны хөтлөлт зэргийг хамруулсан болно.

Дотоод аудитад Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын 2023-2024 оны санхүүгийн тайлангийн аудитад дурдагдсан асуудлыг хамруулаагүй.

Тус байгууллагын санхүүгийн баримтад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд дотоод аудит хийж, илэрсэн 8 зөрчилд улсын ахлах байцаагчийн акт тогтоосон ба биелэлтийг 100% хангасан байна.

**2.3 Аудитын арга, аргачлал**

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчим, ёс зүйн дүрмийг танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтсан асуудлуудыг байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд дотоод аудитын баг хангалттай нотолгоо цуглуулж аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашигласан болно. Үүнд:

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Цалин хөлс олгохтой холбоотой Монгол улсын Засгийн Газрын тогтоол шийдвэрүүд

### 3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Дархан сум нь 2023 онд ISO 9001:2016 стандарт, үүрэг даалгаврын хэрэгжилтийн дотоод ERP систем, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дотоод ERP системийг нэвтрүүлсэн.

#### 3.1 Засаглалын талаар

Байгууллагын засаглалын төлөвшлийн үнэлгээг 8 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 3-р түвшин буюу томъёолсон түвшинд байгаа ба Засаглах удирдлага үйл ажиллагааны журамтай, байнгын үйл ажиллагаатай, зөвхөн шаардлагатай үед дотоод аудит хийдэг, ажилтнууд үнэт зүйлсээ эрхэмлэн, ёс зүйтэй ажиллаж байгаа эсэхийг үнэлэх системтэй, гадаад ба дотоод тайлагналд стандарт тогтоож мөрддөг. Ил тод байдлыг засаглалын хамгийн чухал үзүүлэлт гэж тунхаглан хэрэгжүүлдэг. Олон нийтэд зохих мэдээллийн ил тод гаргаж мэдээлдэг байна.

Дараагийн түвшинд орохын тулд дотоод аудитын нэгжийн үүргийг тодорхойлж, ур чадвартай ажилтан олж авах, засаглах удирдлага стратеги зорилгоо боловсруулахдаа эрсдэлийн дуршилын түвшинг тодорхойлон үнэлгээ хийж, бууруулах арга хэмжээг авах, ёс зүй, үнэт зүйлсийн талаар байнгын сургалт, хэлэлцүүлэг хийх шаардлагатай.

#### 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 2-р түвшинд буюу давтамжтай түвшинд байгаа ба гүйцэтгэх удирдлага эрсдэлийг тодорхойлж үнэлдэг боловч стратеги, зорилго зорилттой уялдаагүй, том хэмжээний төсөл арга хэмжээнд нэг удаагийн эрсдэлийн үнэлгээ хийдэг. Эрсдэлийн талаар ойлголт зөвхөн удирдлагын түвшинд тогтсон боловч эрсдэлийг удирдаж байгаад дүн шинжилгээ хийдэггүй. Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үздэггүй.

Эрсдэлийн удирдлагын түвшинг ахиулахын тулд гүйцэтгэх удирдлага эрсдэлийг тодорхойлж үнэлэх, байгууллагын эрсдэлийн бүртгэл хөтлөх, ангилалд /стратегийн, үйл ажиллагааны, хүний нөөцийн, санхүүгийн, хууль тогтоомжийн нийцлийн, мэдээлэл технологийн гэх мэт/ үнэлгээ хийх, эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үзэх хэрэгтэй.

### 3.3 Дотоод хяналтын системийн талаар

Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 2-р түвшинд буюу давтамжтай түвшинд байгаа ба Засаглах болон гүйцэтгэх удирдлага хоорондоо хараат бус боловч Засаглах удирдлагаас гүйцэтгэх удирдлагад хяналт тавих үйл ажиллагаа нь хягаарлагдмал, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх дотоод хяналтын журам боловсруулан баталсан боловч дотоод хяналтын үйл ажиллагаа сул байна. Дотоод хяналтын үйл ажиллагааны талаар дотооддоо мэдээлэл дамжуулах үйл явц байгаа боловч зарим дутагдалтай талууд байдаг. Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны сул тал, эрсдэлийн талаар удирдлагад мэдээлэх үйл явц тогтсон.

Дараагийн түвшинд шилжихэд хэрэглэгчийн шаардлагыг хангах замаар сэтгэл ханамжийг нь дээшлүүлэх зорилгоор чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016 стандартыг хэрэгжүүлэхэд боловсруулсан журмуудыг Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-тай нийцүүлэн дотоод хяналтыг хийх, дотоод хяналтын үйл ажиллагааг эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан байнга шинэчлэх, "шүгэл үлээх" гэх мэт мэдээллийг сувгуудыг зохистой ашиглах, дотоод хяналтын үйл ажиллагааг байнга үнэлж, албажуулах шаардлагатай байна.

## 4.АУДИТЫН ҮР ДҮН

### 4.1 Засаглалын хүрээнд

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                           |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 1</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Тушаал шийдвэрийн бичвэр хэсгийг хянадаггүй, улирлыг буруу, огноог алдаатай бичсэн байна. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Нөлөө багатай.                                                                            |
| <b>Бодит байдал:</b><br>Тус газрын 2023, 2024 оны тушаал шийдвэртэй танилцахад ур чадварын нэмэгдэл олгох 2023 оны Б/59, Б/101, 2024 оны Б/147 тушаалын бичвэр хэсэгт сар, улиралыг буруу бичсэн байна. Тухайлбал 2023 оны Б/59 тушаалаар 2023 оны 3 дугаар улирлын ур чадварын нэмэгдлийг олгохоор тушаал гарч олгожээ. Гэтэл уг тушаалд "...2 дугаар улиралд ур чадварын нэмэгдлийг олгосугай." гэсэн байгаа нь хугацааны хувьд зөрчилтэй байна. |                                                                                           |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3 дугаар                                                                                          |                                                                                           |

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

зүйлийн 3.1.7.1 дэх заалтад " бичвэрийн агуулга монгол хэлний өгүүлбэр зүй, найруулга, зөв бичих дүрэмд нийцсэн, энгийн, тодорхой, хоёрдмол утгагүй, аман ярианы болон нутгийн аялга хэлц, этгээд, бүдүүлэг үг хэрэглээгүй, санаагаа зөв илэрхийлсэн байх"

### Асуудлын үндсэн шалтгаан :

- Байгууллагын бичиг хэргийн ажилтан, удирдлагын мэдлэг, ур чадвар хангалтгүй, дотоод хяналт, удирдлагын зүгээс тавих хяналт хангалтгүй .

### Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Хууль журмын хэрэгжилт хангагдахгүй байх

-Удирдлага дотоод хяналтын багаас тавих хяналт сул, ажлын уялдаа холбоо муу

### Зөвлөмж:

Цаашид тушаалыг үнэн зөв, ямар цаг хугацааг хамаарч буйд хяналт тавьж шаардлагад нийцэхүйц гаргаж ажиллах.

## 4.2 Эрсдэлийн удирдлагын хүрээнд

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 2</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Нөлөө ихтэй                         |
| <b>Бодит байдал:</b><br>Эрсдэлийн бодлого журамтай боловч, байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг судлан бүртгэж, үнэлдэггүй.                                                                                                                                                                                                                              |                                     |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4 дэх заалтыг дотоод хяналтын үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлж ажиллах.                                                                                                               |                                     |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан:</b><br>Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачилалын талаар холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулж ажилладаггүй. Эрсдэлийн үнэлгээний талаар ойлголт байхгүй, үнэлгээг хийдэггүй.                                                                                                            |                                     |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b><br>-Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах<br>-Байгууллагын үнэ цэн буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана                                                                                                                                  |                                     |
| <b>Зөвлөмж:</b><br>- Байгууллагын ажиллагсдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналтын нэгж хариуцсан ажиллагсдыг сургалтанд үе шаттай хамруулж, чадавхжуулах<br>- Байгууллагын удирдлага нь хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвартай ажилтанг сонгон авахыг эрмэлзэх<br>- Байгууллагын эрсдэлийг бууруулах үе шаттай арга хэмжээ авах |                                     |

#### 4.3 Дотоод хяналтын хүрээнд:

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                         |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 3</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Дотоод хяналтын нэгж, ажилтан байхгүй дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй байна. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Нөлөө ихтэй                                                                             |
| <b>Бодит байдал:</b><br>Байгууллагад дотоод аудитын нэгж, ажилтан байхгүй. Аливаа зөрчил асуудлыг тухайн үед нь илрүүлж залруулдаг ч энэ нь хангалтгүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                         |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4 дэх заалтыг дотоод хяналтын үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлж ажиллах.                                                                                                                                                                                                                                 |                                                                                         |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоод хяналтын нэгж жилийн төлөвлөгөө боловсруулаагүй, дотоод хяналтын чиглэлээр ажил зохион байгуулаагүй ажлын хариуцлага алдсан.</li> <li>- Дотоод аудитын нэгж байхгүй, гүйцэтгэх удирдлагад энэ тухай ойлголт байхгүй.</li> </ul>                                                                                                                                                                            |                                                                                         |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b><br>Байгууллагад төсөв, санхүүгийн алдагдал хүлээх, ажилтан албан хаагчийг хохироох, хүүхдийн хоолны илчлэг норм, эрүүл аюулгүй байдал алдагдах, төсвийн зарцуулалт, үйл ажиллагаанд тавих хяналт суларна.                                                                                                                                                                                                                                   |                                                                                         |
| <b>Зөвлөмж:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4-д заалтыг дотоод хяналтын үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлж ажиллах</li> <li>- Тушаал шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, улирал бүр тайланг байгууллагын удирдлагад танилцуулах, хамт олны хурлаар хэлэлцэх</li> <li>- Ажил үүргийн хуваарийг сайжруулах, эзэнжүүлэх шаардлагатай.</li> </ul> |                                                                                         |

##### 4.3.1.Санхүүгийн үйл ажиллагаа

|                                                                                                                                                                                       |                                                                                       |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 4</b>                                                                                                                                                              | Ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй, тушаалын хувиас илүү хувиар тооцон олгосон. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                               | Нөлөө ихтэй                                                                           |
| <b>Бодит байдал :</b><br>2024 оны цалингийн баримтыг шалгахад ур чадварын нэмэгдэл олгох тушаал гараагүй байхад 562.5 мянган төгрөгийн нэмэгдлийг үндэслэлгүй олгосон зөрчил илэрлээ. |                                                                                       |

**Байх ёстой шаардлага /шалгуур/:**

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах", 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2. "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ.", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 5. "Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна"

**Асуудлын үндсэн шалтгаан :**

- Байгууллагын дарга, нягтлан бодогчийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг,
- Нягтлан бодогч нэмэгдлийн тушаалыг тулган баталгаажуулаагүй
- Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй
- Дээд шатны байгууллагаас хяналт тавьж ажиллаагүй

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

- Цалин хөлсийг илүү болон дутуу тооцсоны улмаас төсөв, санхүүгийн алдагдал хүлээх
- Албан хаагчийг хохироох

**Акт:**

Тушаал шийдвэргүй олгосон ур чадварын нэмэгдэл 562.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                          |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 5</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Шатахуун зарцуулахдаа шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудсыг дутуу бүрдүүлсэн байна. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Нөлөө ихтэй                                                                              |
| <b>Бодит байдал:</b><br><p>Тус байгууллагын 2023, 2024 оны шатахуун зарцуулалтын тайлан баримтыг шалгахад шатахууны талон олгохдоо шаардах хуудас бичүүлдэггүй, хүлээлгэн өгсөн шатахууны тайлан тооцоог эргэн хянадаггүй, тооцоо нийлдэггүй байна.</p> <p>2024 оны 1-6 дугаар сарын баримтыг тулган шалгахад шатахуун зарцуулж хийсэн ажлын дэлгэрэнгүй тайлан байх боловч 7,000.0 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан байна.</p> |                                                                                          |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br><p>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах", 5.1.5 дахь заалтад "хариуцлагатай байх", 6 дугаар</p>                                                                                                                                                                                                                                                          |                                                                                          |

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000**

зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Холбогдох албан хаагчид тайлан тооцоог нийлдэггүй, зарцуулалтыг эргэн хянахгүй байна.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

- Шатахууны зардал өсч санхүүгийн алдагдал хүлээх
- Анхан шатны баримтгүй зарцуулсанаас акт, торгууль тогтоолгох

**Албан шаардлага:**

Шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудасгүй зарцуулсан 7,000.0 төгрөгийн зөрчлийн давтан гаргахгүй байхыг анхааруулж Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүллээ.

**4.3.2.Бусад хяналтын үйл ажиллагаа:**

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 6</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглаж байгаа хөрөнгийг дахин үнэлээгүй байна. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Нөлөө багатай                                                                   |
| <b>Бодит байдал :</b><br>Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 3 нэр төрлийн 3 ширхэг 1,774.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.                                                                                                                                                                                                            |                                                                                 |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5 дахь заалтад "хариуцлагатай байх"УСНББОУС-ын үндсэн хөрөнгө 17-ийн 49 дэх заалт "Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэж заасантай нийцэхгүй байна |                                                                                 |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан :</b><br>Нягтлан бодогч, няравын мэдлэг, хариуцлагаас хамаарч хөрөнгийн бүртгэл алдаатай бүртгэгдсэн.                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                 |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль журмын хэрэгжилт хангагдахгүй байх;</li> <li>- Санхүүгийн тайлан буруу гарах;</li> </ul>                                                                                                                                                                                                                       |                                                                                 |
| <b>Зөвлөмж:</b><br>Холбогдох хууль тогтоомж журам зааврын дагуу ашиглаж байгаа элэгдэл тооцсон хөрөнгийг шийдвэр гаргах байгууллагад уламжлан дахин үнэлж, тайланд тусгах талаар зөвлөмж өглөө.                                                                                                                                                                                                               |                                                                                 |

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000**

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                         |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 7</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Нөлөө багатай                           |
| Тайлант онуудын санхүүгийн баримтын анхан шатны баримтын бүрдэлийг шалгахад Томилолтын тооцооны хуудсанд ирсэн явсан он сар өдөр бичээгүй, бараа материалын тайланд орлогын баримт байхгүй, 2024 онд 188 хүүхдэд өгсөн дархлуужуулалтын багцын гардуулалтын тайлан байхгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.                                                                                                                                                                                                                                                                                           |                                         |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                         |
| Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 дахь заалтад "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 дахь заалтад "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", гэсэн байна. |                                         |
| Асуудлын үндсэн шалтгаан :                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                         |
| - Дотоод хяналт сул;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                         |
| -Удирдлага, нягтлан бодогчийн эрх зүйн мэдлэг дутуу                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                         |
| Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                         |
| -Хууль журмын хэрэгжилт хангагдахгүй байх;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                         |
| -Санхүүгийн алдагдал хүлээх;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                         |
| Зөвлөмж:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                         |
| Нярав анхан шатны баримтыг иж бүрэн үнэн зөв бүрдүүлэх, түүнийг нягтлан бодогч шалгаж хүлээж авч байх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                         |

## 5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад "САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ" гэсэн дүгнэлтийг өгч байна.

| Дүгнэлтийн төрөл        | Дүгнэлтийн тайлбар                                                                                                                                                                                              |
|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сайжруулах шаардлагатай | Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давамжтай" буюу 2-р түвшинд байна гэж үнэлсэн.<br>Аудитаар илэрсэн асуудлуудын 57.1 %-аас дээш "нөлөө ихтэй" гэж үзсэн. |

**Дүгнэлт:****Засаглалын хүрээнд:**

Байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого журамтай боловч эрсдэлээ зөв тодорхойлоогүй, байгууллагын эрсдэлд чиглэсэн дотоод хяналт үр нөлөө багатай байна.

**Эрсдэлийн удирдлагын хүрээнд:**

Байгууллагын хэмжээнд эрсдлийн түвшинг тогтоож, бодлого журам баталсан боловч эрсдэлийг шинэчилдэггүй, эрсдэлийн үнэлгээ хийдэггүй, эрсдэлийн удирдлагын болон үйл явц нь бүрэн тогтоогүй, байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үздэггүй байна.

**Дотоод хяналтын хүрээнд:**

Засаглах удирдлагаас гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтыг хэрхэн бүрдүүлж хэрэгжүүлж байгаад хяналт тавьдаггүй, дотоод хяналтын бодлого журам боловсруулаагүй дотоод хяналтын нэгжгүй, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй байна.

**Зөвлөмж:****Засаглалын хүрээнд:**

- 2025 оноос шинээр мөрдөх байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж Засаглах удирдлагаар батлуулах;

- Удирдлагын тушаал шийдвэрийг гаргахдаа албан хэрэг хөтлөлтийн стандартыг дагаж мөрдөх, төсөлд хяналт тавьж хэвших;

- Удирдлагаас гаргаж буй шийдвэр болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

**Эрсдэлийн удирдлагын хүрээнд:**

- Эрсдэлийн баг нэгжийг байгуулж, байнгын үйл ажиллагааг ханган ажиллах

- Эрсдэлийг тооцож, эрсдэлийн бүртгэлийг хийж холбогдох үнэлгээг шаардлагатай бүх тохиолдолд хийж эрэмбэлдэг байх;

- Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх явцдаа залиланг харгалзан үзэх;

- Эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүртгэлжүүлж эрсдэлийг бууруулах арга хэмжээг цаг алдахгүй хэрэгжүүлдэг байх;

**Дотоод хяналтын хүрээнд:**

- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг

журам"-ын 4 дүгээр зүйлд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж тайлагнах;

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

М.ГАНЦЭЦЭГ

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Ш.ОТГОН

ТАЙЛАН ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Л.ДАГИЙСҮРЭН

ТАНИЛЦСАН:

ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.АМАРЗАЯА

НЯГТЛАН БОДОГЧ

Ж.ЦОГБАЯР

Дархан-Уул аймгийн Дархан сумын ЗДТГазрын  
2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар  
тогтоогдсон зөрчил төлбөрийн жагсаалт

Төсвийн  
2025 он

| №   | Хариуцаж хувий<br>оёсг нэр | Албан тушаал                                               | Зөрчил төлбөрийн товч утга                                                                                  | Ахтын дугаар | Албан<br>шаардлагын<br>дугаар | Нийт дүн  | Үүнээс                        |                                                |                                      | Зөвлөмж өгөх |
|-----|----------------------------|------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|-------------------------------|-----------|-------------------------------|------------------------------------------------|--------------------------------------|--------------|
|     |                            |                                                            |                                                                                                             |              |                               |           | Төсвөрт<br>төвлөрүүлэх<br>дүн | Тухайн<br>байгууллага<br>хувь хүний<br>далсанд | Хуулийн<br>байгууллагад<br>шилжүүлэх |              |
| 1   | Ц.Амарзаяа<br>Ж.Цогбаяр    | Даргын үүргийг түр<br>орлон гүйцэтгэгч,<br>нэгтгэвч бодогч | Тушаал шийдвэрийн бичлээр хэсгийг хянадаггүй,<br>угарлыг буруу, огноог алдаатай бичдэг                      |              |                               |           |                               |                                                |                                      | Зөвлөмж      |
| 2   | Ц.Амарзаяа<br>Ж.Цогбаяр    | Даргын үүргийг түр<br>орлон гүйцэтгэгч,<br>нэгтгэвч бодогч | Эрсдэлээ үнэлдэггүй, баг, нэгжгүй                                                                           |              |                               |           |                               |                                                |                                      | Зөвлөмж      |
| 3   | Ц.Амарзаяа<br>Ж.Цогбаяр    | Даргын үүргийг түр<br>орлон гүйцэтгэгч,<br>нэгтгэвч бодогч | Байгууллага дотоод, хяналтын нэгжгүй, бодлого<br>журамгүй байна.                                            |              |                               |           |                               |                                                |                                      | Зөвлөмж      |
